ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 11 сарын 30 өдөр Дугаар 129 Эрдэнэт

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Аймгийн хэмжээнд бүтээмж, инновацийн хөдөлгөөний бодлогыг тодорхойлж, "Мэдлэгт суурилсан Эрдэнэт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх үүрэг бүхий бүтээмж инновацийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Бүтээмж, инновацийн аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтын ёсоор баталсугай.

2."Мэдлэгт суурилсан Эрдэнэт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний жил бүрийн төлөвлөгөө, төсвийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулж хэрэгжилтийг Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлж ажиллахыг зөвлөл /П. Пүрэвлхагва/-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 81 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА П. ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100246

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны
11 дүгээр сарын 28-ны өдрийн 119 дугаар
тогтоолын хавсралт

БҮТЭЭМЖ ИННОВАЦИЙН АЙМГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: - Аймгийн ИТХ-ын дарга

Орлогч дарга: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:
- "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан дэд захирал бөгөөд ерөнхий инженер
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн боловсрол соёл урлагийн газрын дарга
- "МУИС-ийн Орхон салбарын захирал
- Технологийн сургуулийн мэргэжлийн сургалт хариуцсан орлогч захирал
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал
- Хүнс ХАА-н газрын жижиг дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн мэргэжилтэн
- Хангайн бүсийн бүтээмж хөгжлийн төвийн гүйцэтгэх захирал

Нарийн бичгийн дарга: - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

оОо